

**НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРЭЛДЭН**  
**ТӨЛӨВШСӨН НЬ**

М.Жавзансүрэн докторант

МУИС, НШУС, Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** Монгол улсад нутгийн өөрөө удирдах ёсны эх үүсвэр 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд тавигдсан хэдий ч Манжийн ноёрхолын үеийн “аймгийн чуулган”, ХХ зууны “ардын хурал”, “хөдөлмөрчин ардын хурлууд” аас улбаалан хөгжиж өнөөг хүрсэн нь 1990 оноос хойш жинхэнэ утгаараа бүрэлдэн тогтож, хөгжлийн мөн чанарыг олоход түлхэц болсон юм.

Ардын Депутатын хурал хэмээх ойлголт буюу өнөөгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын эх үүсвэр анх тавигдахдаа “хурал” нэртэйгээр түүхэнд үлдсэн бөгөөд “Хүмүүс болон аль нэг байгууллагын гишүүд нийлж, хэрэг зүйлийг хэлэлцэх цуглаан”<sup>84</sup> гэсэн утгаар нь анх хэрэглэжээ. 1990 оноос өмнө “Ардын төлөөлөгчдийн байгууллага”, “Ардын төлөөлөгчдийн байгууллагын систем”, “Төлөөлөх ёс” гэсэн утгаар нь өргөн хэрэглэж ирсэн байна.

Б.Пүрэв “Төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллага гэдэгт “ард түмнээс засгийн эрх барих хэргийг гардан гүйцэтгүүлэхээр өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчдийг сонгон байгуулсан төрийн байгууллагуудыг хэлнэ”<sup>85</sup>, Профессор А.Ким “Төрийн эрхийг барих төлөөлөгчдийн байгууллага гэдэгт бид ардын төлөөлөх ёсыг хэрэгжүүлэх зохион байгуулалт эрхийн хэлбэр”<sup>86</sup>, Л.А.Григорян “Төлөөлөгчдийн байгууллагуудын систем”<sup>87</sup> хэмээн өөр өөрийн байр сууринаас тайлбарласан байна.

1940 оны үеэс Хөдөлмөрчин ардын хурал хэмээн нэрлэхдээ ард түмний төлөөлөл болдог гэсэн утгаар нь хэрэглэсэн бол 1949 оноос Хөдөлмөрчдийн Депутатуудын хурал гэсэн нь “Депутат” буюу “Ардын төлөөлөгч”, “Төрийн байгууллагын сонгогдсон төлөөлөгч” гэсэн утгаар нь хэрэглэсэн нь ЗХУ-ыг хуулбарлан дууриасан мэт боловч тухайн үедээ оновчтой, нэг үгээр утга санааг илэрхийлэх гэсэн нь илэрхий. Харин 1990-ээд оноос хойш иргэд олон нийтийн төлөөлөл болдог гэсэн утгаар нь Иргэдийн төлөөлөгчдийн хурал хэмээн нэрийдэж,

<sup>84</sup> Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966. 731-р тал

<sup>85</sup> Б. Пүрэв. Социалист төрийн эрх барих тухай ленинч сургаал БНМАУ-д хэрэгжсэн нь. УБ. 1981. 9 тал

<sup>86</sup> А.И.Ким.Государственная власть и народное представительство в СССР.Томск.1975.стр 130

<sup>87</sup> Л.А.Григорян.Социалистическая государственная власть и представительная форма ее осуществления .“Советская государство и право”.1969.№3.стр 91

нутгийн өөрөө удирдах байгууллага гэж нэрлэснээр агуулгын хувьд далайцтай, ардчилсан шинжийг агуулах болсон байна.

Ардын Депутатын Хурлын хөгжлийн түүх буюу өнөөгийн нутгийн өөрөө удирдах байгууллагын хөгжлийг нэхэн үзэхийн өмнө хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэн дэх эрх зүйн анхны хэлбэрийг үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Нутаг дэвсгэрийн нэгжийн хувиарлалтын эрх зүйн анхны хэлбэр нь эртний Ром хотоос үүдэлтэй хэмээдэг. Хэдийгээр нутгийн өөрөө удирдах ардчилсан мөн чанарыг тусгаж чадаагүй ч хэлбэрийн төдий боловч илэрхийлж байсан гэж үзэх талтай. МЭӨ 753 оноос эхлэлтэй Ром хотын нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын бүтэц нь община (нийгмийн зохион байгуулалтын уламжлалт хэлбэр) шинжтэй байсан ба эхэн үедээ 3 аймгийн 300 гаруй овгийг нутаг дэвсгэрийн зарчмаар нэгтгэсэн байдаг. 10 овог нь 1 курий, 10 курий нь 1 аймаг болж улмаар 30 курий, 4 трибутын (тойрог) зохион байгуулалтай байв. Курийн хурал, трибутын хурал, центуратын хурал нь тус тусдаа нутаг дэвсгэрийн харъяаллын асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан нь орон нутгийн ардын хурлын зохион байгуулалтын эхлэл болсон гэж үзэх үндэстэй.

Өнөөгийн Итали дахь соёлын төв болсон Флоренц нь Европын томоохон хотуудын нэг байсан төдийгүй 1293 онд “Ordamenti di giustizia” (шударга ёсны зарчмаар) үндсэн хуультай болсон билээ. Тэрхүү үндсэн хуулиар бол хотын зөвлөл болон хотын 6 дүүрэгт гар үйлдвэрлэлийн 21 нийгэмлэгт идэвх бүхий гишүүд сонгогдох болсон юм.

Түүнчлэн хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхийн дунд үеийг тодорхойлж байсан XIII зуунд Чингисийн байгуулсан Их Монгол улсын үед мянгатын зохион байгууллалтай байж, баруун, зүүн, төвийн түмнийг байгуулж, тус тусдаа ноёдын зөвлөлтэй байсан төдийгүй тэрхүү түмтийн ноёдыг сонгохдоо угсаа гарвал бус авьяас, чадвар, эр зориг, шударга чанарыг гол болгож байсныг бид мэдэх бөгөөд “Их Засаг” хуулиндаа хуульчилж өгсөн нь хурлын тогтолцооны түүхийг түүчээлэн авч явсан юм.

Одоогийн Мексикийн нутагт оршин тогтнож байсан Теночтитлан нийслэлтэй Ацтекийн эзэнт улс нь тус бүр ахлагчаар удирдуулсан овгуудтай байсан ба тэдгээр овгууд нь аймгийн зөвлөлд захирагдан төр ба шашны удирдагчдыг сонгодог<sup>88</sup> байв. Өөрөөр хэлбэл орон нутгийн төлөөлөгчдийн эрх барих байгууллага анхлан үүссэн гэж үзэх болох талтай.

1648 оны Вестфалийн энхийн гэрээний үндсэн дээр хамжлагт ёсны хуучин тогтолцоо байр сууриа өгч, улс үндэстнүүд Европт бүрэлдэн төрийн байгууламжийн хэлбэрүүд төлөвшин, 1689 оны Английн эрхийн тухай билльд төлөөлөгчдийн хурлын үзэл санаа тусгагдсан бол Их Британид өөрөө удирдах байгууллага нь муниципалитетийн шинжийг хэлбэрийн төдий ч гэсэн хадгалж байв.

<sup>88</sup> Европын түүх. УБ.2000 тал 29

1789 онд Францын хувьсгалын үр дунд баталсан “Хүний эрхийн тухай тунхаглалд”<sup>89</sup> “Бүх иргэд өөрсдийн болон төлөөллийн байгууллагаар дамжуулан эрхээ эдлэх” талаар заасан бөгөөд цаашлаад нутгийн эрх барих эрх зүйн үндэс нь 1792, 1798, 1870 онуудад шинэчлэгдэж, 1980 оноос жинхэнэ утгаараа бурэлдэн бий болсон юм. 1789 онд Францын засаг захирагааны шинэ зохион байгуулалтанд өөрчлөлт оруулсан нь хувьсгалын эхний жилүүдийн томоохон ололт болов. Дундад зууны үеэс хэсэгчлэн хувааж ирсэн тогтолцоог угстаж, шинэ зохион байгуулалтанд шилжүүлж, 83 мүжид бүх газар нутгийг тэгш хуваасан байна. Мужийг 8 хунээс бурдсан директори (17) удирдах болов.<sup>90</sup> Үчиний дараагаар 1791 онд батлагдсан анхны үндсэн хууль “Захиргааны байгууллага, тушмэдүүд бол төлөвлөгчдийн шинж чанаргүй, харин ард түмнээс сонгогдсон дэвшигдсэн албатай адил бөгөөд хааны эрх мэдэл, хяналт дор удирдлагын чиг учргийг хэрэгжүүлнэ” хэмээн заасан байна.Өөрөөр хэлбэл департамент нь районы захиргааг удирддаг боссоо тогтолцоотой болсон юм. Ийнхүү Францц орон нутгийн эрх барих байгууллагын төвлөрсөн тогтолцоог бэхжүүлсэн хэдий ч 1800-аад оны үед Наполеон өөрийн застийг хууль зүйн хувьд баталгаажуулахыг шаардсанаар шинэ үндсэн хуультай БНУ болсон боловч засгийн бүх эрх мэдэл консулын гарг төвлөрч, департамент, перерсектурыг, мөн сайд нарыг ч | консул томилж эрх мэдэлдээ байлгах болсоноор<sup>90</sup> орон нутгийн өөрийн удирдлагыг угий болсон юм.

Харин 1871 онд департаментын зохион байгуулалтын хууль, 1874 онд коммуны тухай хуулийг батлан гаргаснаар нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгогдон байгуулагдах журам харьцаангуй бие дааж үйл ажиллагаа явуулах боломжтой болсон.

1808 онд Германц хотын эрх зүйн тухай хуулийг гаргасанаар хотын өөрөө удирдах ёсиг анх удаа хуплээн зөвшөөрсөн анхны тохиолдол болсон.

1860 онд Австрийн эзэн хаан Франц-Иосиф шинэ үндсэн хууль мөрдөх зарлиг гарган, явцуу хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан рейхсратийг өргөжүүлэн гишүүдийг нь тухайн газар нутгийн ландтагаас нэр дэвшигтсэд дотроос эзэн хаан өөрөө томилгох болжээ. Хууль, боловсрол гэх мэт тухайн газар нутагт хамаарах асуудлыг төв засгийн газрын мэдлээс гарган, ландтагуудад шилжүүлэн өгсөн<sup>91</sup> нь орон нутгийн язгууртнуудын эрх мэдлийг бий болгосон юм.

1862 онд Шведэд нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулийг батлан гаргаж, орон нутагт эрх мэдлийн хуваарилалт тогтоож, орон нутгийн түвшинд эрх барих, шийдвэр гаргах, хяналт тавих, үүрэг хэрэгжүүлэх, гүйцэтгэх болсон нь тухайн өддээ шинэлэлгээ зүйл байв.

1831 оны Бельтийн үндсэн хуульд төрийн эрх мэдлийг зөвхөн орон нутгийн түвшинд хуульчлан тодорхойлж байжээ.

<sup>89</sup> Европын түүх. УБ.2000 Тал 177

<sup>90</sup> Европын түүх. УБ.2000 Тал 224

<sup>91</sup> Европын түүх. УБ.2000 Тал 374

Харин дэлхийн түүхэнд төрийн эрх мэдлийг анх удаа хувиарлаж өгсөн АНУ-ын үндсэн хуулинд засаг захиргааны хуваарилалтын талаар дурдсан хэдий ч орон нутгийн эрх барих байгууллагын тухай дурьдагдаагүй байдаг.

XIX зууны II хагасаас эхлэн АНУ, Франц, Герман, Бельги, Польш, Шведийн үндсэн хуулиудад нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн үндсийг томъёолж, XX зуунд дээрх улсууд нутгийн удирдлагыг үндсэн 1917 онд Мексик улс үндсэн хуулиндаа нутгийн эрх баригчид нутаг дэвсгэрийн асуудлаа өөрсдөө шийдвэрлэх эрхийг өгөхөөр тогтоосон, 1919 онд Герман үндсэн хуулиндаа обишинууд хуулийн хүрээнд өөрөө өөрсдийгөө удирдах эрхтэй, 1946 онд Франц улс үндсэн хуулиндаа “орон нутгийн хамтруууд нь бүх нийтийн шууд сонгуулиар байгуулагдсан зөвлөлүүдийг удирдах эрхтэй”, 1947 онд Япон улс үндсэн хуулиндаа “ эрх барих орон нутгийн байгууллагууд нь хурлын төлөөлөгчдийн зөвлөлдөх байгууллагын хэлбэрээр хуулийн дагуу байгуулагдана”, 1949 онд Баварын үндсэн хуулинд орон нутгийн эрх хэмжээний асуудлын жагсаалтыг гаргасан, 1953 онд Шведэд нутгийн удирдлагын нэгдсэн хууль гарсан зэрэг дэлхийн улс орнуудад нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо МЭӨ 753 оноос Ром хотоос эхлэн, XIX зуунд бүрэлдэн тогтож, XX зуунд улс орнуудын хэмжээнд өргөн тархаж, үндсэн хуулийн салшгүй үнэт зүйлс болж ирсэн байна.

Тэгвэл бид МЭӨ III зууны үеэс төрт ёсны түүхээ байгуулан, өөрийн гэсэн соёл иргэншлийг бий болгон Монголд өнөөгийн нутгийн өөрөө удирдах байгууллага хэрхэн үүсч, бүрэлдэн тогтсон тухайд судлан тодруулах нь бидний судалгааны ажлын нэгээхэн хэсэг юм.

Монголын ард түмэн өнө эртний уламжлалтай төдийгүй айл гэр, ах дүү элгэн саднаараа нэгдэн “бүгдээрээ зөвлөвөл буруугүй бүлээн усаар угаавал хиргүй” хэмээн амьдралын болоод нутаг орныхоо тулгамдсан асуудлуудыг өөр хоорондоо зөвшшилцөн, ахмадынхаа үг сургаал, туршлагад тулгуурлан шийдвэрлэж ирсэн хийгээд Ураг төрлийн байгууллын үеэс овог нийтийн эрх ашгийг илэрхийлж хэрэг явдлаа хэлэлцэн шийдвэр гаргадаг “Эе” гэдэг цуглаантай байсан нь нүүдэлчдийн соёл иргэншилд бий болгосон нутгийн өөрөө удирдах ёсны хэв шинжийн эх үүсвэр байсан.

Төр бол аливаа улсын амин сүнс байдаг. Тэр утгаараа ардчиллын элементийг өөртөө багтаасан “аймгийн чуулган”,(Аймгийн чуулган нь манж жанжин амбасын хяналтын дор тухайн аймгийн бүх хэргийг зөвлөлдөн шийдвэрлэх газар<sup>92)</sup>) XX зуунд “ардын хурал”<sup>93</sup>, “хөдөлмөрчин ардын хурлууд”<sup>94</sup> байгуулагдаж нутаг нуга, улс орныхоо асуудлыг олуулаа буюу сонгосон төлөөлөгчөөр дамжуулан тал бүрээс нь тунгаан хэлэлцэж шийддэг, их, бага хаадаас эхлээд ард түмэн, иргэдийг төрийн хэрэгт оролцуулах “ардчиллын зорилго бүхий” ажиллагааг улам бүрээр хөгжүүлсээр иржээ.

<sup>92</sup> Болдбаатар.Ж. Лүндээжанцан.Д. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал.УБ.1997.тал 144

<sup>93</sup> 1924 оны үндсэн хууль. УБ.1924.Монгол улсын 14 он

<sup>94</sup> Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004. тал 149

Сурвалж бичиг судалгааны бүтээлүүдээс харахад Манжийн ноёрхолын үеэс бий болсон засаг захиргааны зохион байгуулалт нь Богд хаант Монгол улсын үед ч хэвээр хадгалагдсан бөгөөд бага сага өөрчлөлт хийгдсэн нь Хан уулын чуулганыг Богд хан хайрхан уулын чуулган, Бидэръяа нуурын чуулганыг Хан тайшир уулын чуулган болгон тус тус өөрчилсөн байна. Мөнхүү Цэцэрлэгийн чуулганыг хэвээр үлдээж, Дөрвөдийн зүүн гарын Бат-Ерөөлт төгс хөлөг далай хан аймаг, баруун гарын Үнэн зоригт хан аймаг чуулах газраа тухай бүр сонгож байхаар тогтсон байна. Ийнхүү 6 аймгийн чуулган чуулж байсан ба гурван жилд нэг удаа чуулан, албан тэгшитгэх, чуулган дарга дэвшүүлэх зэрэг аймаг, орон нутгийн холбогдолтой чухал асуудлуудыг хэлэлцдэг байсан нь орон нутгийн эрх барих байгууллагын хөгжлийн улбаа байсан юм.

Харин орон нутгийн засаг захиргааг ардчилсан үндсэн дээр халж өөрчлөх ажил 1921 оны ардчилсан хувьсгалын дараагаар тавигдсан ба хууль эрх зүйн үндэс нь 1920-иод онд бий болсон юм.

“Монголын үнэн” сонини 1920 оны XI.10 ны дугаарт “Гадна, дотны мөлжих дарлах зүйлүүдийг шүүрдэн арилгаж, улс төрийн эрх мэдлийг ард олон өөрснөө эзлэн авч, чухам итгэлтэй үнэнхүү санаанаас олны тусыг хичээх хэрэг үйлсээ явуулан чадах шударга эрдэмтэй сайн хүн нарыг ард өөрснөө сонгож улсын засаг бариулна”<sup>95</sup> хэмээгээд “21 насанд хүрсэн иргэд бүгдээрээ цуглан хуралдаж, сумын хурлыг байгуулаад, цааш цааш нь дээд шатны хурлыг шат дамжуулан сонгож байгуулах”<sup>96</sup> тухай зааж өгсөн явдал нь орон нутгийн эрх барих байгууллагын эхлэл болж байв.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараах түүхэн үйл явцын нэг нь засгийн бүх эрхийг ард түмний гарг өгөх зорилт байсан бөгөөд үүнийг шийдэх эхний арга хэмжээ нь орон нутгийн засаг захиргааны асуудлыг цэгцэлж, ардын төлөөлөгчдийн байгууллагын эх үүсвэр болох хурлыг байгуулах явдал байсан юм.

Ардын засгийн эхний үед хувьсгалын өмнөх засаг захиргааны зохион байгуулалт үндсэндээ өөрчлөгдөж, цаашид улам боловсронгуй болсоор байсан юм. Үүнийг доктор М.Санждорж:

- Засаг захиргааны зохион байгуулалтыг үндсээр нь өөрчилсөн үе (1921-1931)
- Засаг захиргааны зохион байгуулалт тус улсын хөгжлийн хир хэмжээ, шаардлагад тохирон хөгжингүй боловсронгуй болж ирсэн үе (1931 оноос хойш)<sup>97</sup> хэмээн 2 хуваасан байдаг.

1921 оны IX сарын 5 нд нийслэл Хүрээнд байнга зөвлөлдөх байгууллага болох улсын түр цагийн хурал байгуулагдаж, түүний бүрэлдхүүнд аймаг, шавь

<sup>95</sup> МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940. УБ. 1966. 17 тал

<sup>96</sup> Мөн тэнд. тал 24

<sup>97</sup> Санждорж. М. БНМАУ-ын засаг захиргааны зохион байгуулалт тогтон хөгжсөн үе. Ардын тэр. 1970. №3 тал 36

бүрэс 5 ард, нийгээд язгууртан төлөөлөгч, мөн цэрэг НТХ, ХЗЭ-ийн хорооноос зохих тооны төлөөлөгч оролцуулахаар шийдвэрлэжээ. Тэрчлэн дээрх хурал шиг төлөөлөгчдийн байгууллага аймаг, хошуудад байгуулагдаар байв. Энэхүү түр цагийн хурал нь АДХ-ын эх үүсвэр байсан<sup>98</sup> хэмээн үзсэн байдаг. Түр цагийн хурал нь хожмын АДХ-ын үйл ажиллагааны зарчим тодорхой хэмжээгээр тусгагдсан учир агуулгаараа үндсэн хуулийн ач холбогдолтой баримт бичиг байсан юм.

Орон нутгийн засаг захиргааг өөрчлөх асуудал үндсэндээ 1923-1924 он хүртэл үргэлжилсэн ба баг, сумуудын хурлаар цаашид тавих зорилтоо тодорхойлж өгсөн байна.

1923-1925 онд “Монголын олон засаг ба засаг бус ван, гүнгүүдийн рэх хэмжээний дүрэм” (1922), “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”(1923), “Их шавийн захиргааны дүрэм”(1923), “Ховдын харьят газрын захиргааны дүрэм” (1924), “Дарьгангын нутгийн захиргааны дүрэм”, “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм”<sup>99</sup> зэргийг баталсан. Эдгээр дүрмийг үндэслэн засаг захиргааны байгууллага байгуулах ажил өрнөсөн бөгөөд үүний үр дүнд арван, гэр, хошуу, сум, багаас хурал байгуулжээ.

“Нутгийн захиргааны дүрэм” ёсоор арван гэрийн хурлууд бий болж, засаг захиргааны удирдлагад байгаа засаг ноёдыг ардын төлөөлөгчөөр сольсон явдлыг доктор М.Санждорж “... ард олны үндсэн ашиг сонирхлын асуудлууд хэлэлцэн нутгийн захиргааны эрх баригчдыг сонгосон нь тус орны түүхэнд урьд өмнө үзэгдээгүй улс төрийн гүн гүнзгий ач холбогдолтой цоо шинэ үзэгдэл байв” хэмээгээд “... Монголд төрийн эрх барих хурал хэмээх ардын төлөөлөгчдийн байгууллагын систем тогтжээ<sup>100</sup> хэмээн дүгнэсэн байдал.

Академич Ж.Болдбаатар, доктор Д.Лүндээжанцан нар “ Ардын засгийн газар орон нутгийн засаг захиргааны өөрчлөлт хийхдээ тун болгоомжтой хандаж, уян хатан тактик баримталсан юм”<sup>101</sup> хэмээгээд “Төрийг удирдах хэрэгт олон түмнийг өргөнөөр оролцуулах хэлбэр-арван гэр, баг, сум, хошуу, аймаг, шавийн төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдсан нь ардын төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл тогтолцоо төлөвшин хөгжих үндсийг бүрдүүлжээ”<sup>102</sup> гэж төрийг удирдах хэрэгт олон түмнийг оролцуулсан нь чухал алхам болж чадсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Дээрх дүрмийг үндэслэн Монгол оронд ардчилсан засаг захиргааны байгууллага байгуулах ажил 1923-1924 онд хэрэгжсэн хийгээд Улсын анхдугаар

<sup>98</sup> Даваахүү. Д. АДХ бол жинхэнэ ардын төрийн байгуулал мөн. Үнэн. 1975.05.23.№122 (12795)

<sup>99</sup> Сономдавга.Ц. БНМАУ-ын Орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд.УБ.1967.тал

<sup>100</sup> М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ.1974. тал 116

<sup>101</sup> Болдбаатар.Ж.Лүндээжанцан.Д. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ. 1997 тал 221

<sup>102</sup> Мөн тэнд тал 222

хурлаар анхны Үндсэн хуулиа баталж , “ . . . Бүгд найрамдах засгийг явуулан Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалуулахаар тогтоон зарласан учир бидний олон аймаг, хотуудын Хурлаас томилсон төлөөлөгчид бүгдээрээ цуглан хуралдахыг . . . ” онцлон зааж, хууль эрх зүйн хувьд баталгаажуулж өгсөн юм.

1924 оны Үндсэн хуулийт эрдэмтэн судлаачид “Монгол төрийн түүхнээ анх удаа хаант ёсыг халж, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулж, туурга тусгаар Бүгд найрамдах улсаа тунхаглан зарласнаараа түүхэн ач холбогдолтой баримт бичиг мөн” гэж дүгнэсэн байдаг. Түүнээс гадна орон нутгийн эрх барих байгууллагын анхны хууль зүйн акт болж чадсан гэдэг нь маргаангүй билээ.

1924-1940 он хүртэл хэрэгжсэн Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлал нь гүйцэтгэн захирамжлах байгууллагын үүргийг өргөтгөсөн, удирдлагын босоо тогтолцоог бэхжүүлсэн байдал ажиглагдаж байна.

Анхдугаар Үндсэн хуулиар “Орон нутгийн хурал” гэж нэрлэснийг 1949 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр аймаг, хотын “Хөдөлмөрчин ардын хурал” болгон өөрчилснийг ард иргэдийн оролцоог төлөөллийн байгууллагаар нь дамжуулан илүү идэвхтэй, үр нөлөөтэй ажиллуулахад анхаарсан хэрэг гэж үзэж болох талтай. Ийнхүү 1921 оны хувьсгалын дараагаар Монголын улс төрийн түүхэнд өнөөгийн нутгийн удирдлагын тогтолцоо төлөвшин бий болж, эрх зүйн хувьд хэлбэршин тогтох, хөгжлийн мөн чанараа олсон төдийгүй 1990 оноос ардчилсан шинжийг жинхэнэ утгаар өөртөө агуулж, нутгийн удирдлагын тогтолцооны түүх шинэ шатанд гарсан юм.

**Abstract:** The research covers the history of local administrative organizations so called public assembly, labourer's public assembly, labour representative's assembly, public representative's assembly and historical development of their structure and legal status.